Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Мянгад сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2021 оны 03 дугаар сард дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 7.937,8 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 158.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 127.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,185.7 сая төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн данснууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан /сая. төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	59.2	78.4	-19.2	132%
Авлага	282.5	270.4	12.1	96%
Бараа материал	210.5	259.3	-48.8	123%
Үндсэн хөрөнгө	5,357.4	6,477.9	-1,120.5	120%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,948.2	7,133.9	-1,185.7	119%
Богино хугацаат өр төлбөр	2.8	47.1	-44.3	168%
Цэвэр хөрөнгө, өмч	5,945.3	7,086.7	-1141.4	119%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,948.2	7,133.9	-1,185.7	119%

Эх сурвалж: Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 59.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 78.4 сая төгрөг болж 19.2 сая төгрөгөөр буюу 32 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 78.4 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 282.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 270.4 сая төгрөг болж буурч 12.1 сая төгрөг буюу 4 хувиар буурсан байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая.төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.5	4.6	(4.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	0,08	26,7	25.9
Байгууллагаас авах авлага	33.2	13.8	(19.4)
Хувь хүмүүсээс авах авлага	7.6	6.8	(0.8)
Зээлийн хүүгийн авлага	11.5	12.1	0.6
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	0.74		(0)
Татаас санхүүжилтийн авлага	1.2	0.05	(4.1)
Дүн	219.5	206.2	(13.3)
Урьдчилж гарсан зардал	38.5	47.8	9.3
Дүн	38.5	47.8	9.3
АВЛАГЫН НИЙТ ДҮН	282.5	270.4	(12.1)

Эх сурвалж: Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 229.4 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 219.5 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 28.0 сая төгрөгийн зээл олгож, 41.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 206.2 сая

төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй хашааны авлагын эхний үлдэгдэл 8.0 сая төгрөгөөс тайлант онд 6.8 сая төгрөгийн авлагыг барагдуулж ЗДТГ-ын 20.5 сая төгрөгийг авлага, урьдчилж олгосон зардлаар олгон 47.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 210.5 сая төгрөг болж 48.8 сая төгрөгөөр өссөн нь 8.9 сая төгрөгөөр эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 210.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 48.8 сая төгрөгөөр нийт 259.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 313.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 5,357.4 сая төгрөг байсан бол оны эцэст 6,477.9 сая төгрөг болж 1,127.1 сая төгрөгөөр өссөн нь 4.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 10.9 сая төгрөгөөр хандив, 1,111.6 сая төгрөгийг бусад, сумын ЗДТГ-ын өмнөх онд барилга байгууламжийн үлдэгдлийг буруу тооцсонтой холбоотой 306.1 сая төгрөгөөр шилжүүлэн авсан холбоотой байна .

Тайлант онд үндсэн хөрөнгө 4.5 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 1,127.1 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй хандиваар нэмэгдэж, акталсан, балансаас балансад шилжүүлсэн 186.6 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.8 сая, эцсийн үлдэгдэл 47.2 сая төгрөг болж 44.4 сая төгрөгөөр өссөн байна. ЭМТ-ийн эмийн өр 39.0 сая төгрөг байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 47.2 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

Үүнээс: Ажилчидтай холбоотой өглөг 1.4 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 43.3 сая төгрөгийн татварын өглөг /ТӨҮГ/ 0.3 сая төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөг 2.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 5,945.4 сая төгрөг байсан оны эцэст 7,086.7 сая төгрөг тайлант онд 1,141.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 870.8 сая төгрөгийн ашигтай, өмнөх үеийн үр дүн рүү 1,605.0 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,736.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,736.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Мянгад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,518.6 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,736.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 3/04 тоот тогтоолоор 2,736.1 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,736.1 сая төгрөгийн төсөв баталснаас 1,589.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 786.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36.5 сая төгрөгийг ЭМДС-аас, 141.1 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 43.6 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл	сая. төгрөг	төлөвлөгөө	гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих		1,547.8	1,589.3
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1,547.8	1,589.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих		787.2	786.2
Орон нутгийн төсвөөс		674.9	645.1
Орон нутгийн хөгжлийн сан		112,3	141,1
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих		36.7	36.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		36.7	36.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		44.0	44.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос		1.1	0.6
Туслах үйл ажиллагааны орлогоос		42.9	43.6
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН		2,415.7	2,456.2

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,589.3, орон нутгийн төсвөөс 786.2, ОХНС-ийн санхүүжилт 141.1 сая төгрөг, ЭМДС-аас санхүүжих 36.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 43.6 сая төгрөг нийт 2.795,4 сая төгрөгийн төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2.747,7 сая төгрөгийг зарцуулж 49.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,526.7 сая мянган төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,646.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 259.9, бараа хангамж, бараа материалын зардал 49.2, томилолтын зардал 4.0, нормативт зардал 131.3, бараа үйлчилгээний бусад зардал 72.8, хөрөнгийн зардал 12.4, эргэж төлөгдөх зээл 50.0 сая төгрөгөөр буюу нийт 158.9 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлого 50.3 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 76.7 сая төгрөгөөр нийт 77.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Нийт бүрдүүлсэн орлогын 41.5 сая төгрөгийг СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого, 34.8 сая төгрөг нь малжуулах төслийн эргэн төлөлт, 0.3 сая төгрөг нь ЕБС-ийн өөрийн орлого бүрдүүлэн төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг 26.4 сая төгрөгөөр давуулж биелүүлж 31.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Мянгад сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 3/04 дугаар тогтоолд Мянгад сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 129.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 143.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	129.6	143.3	(13.7)
Нийт орлого ба тусламжийн дүн	129.6	143.3	(13.7)
Татварын орлого	129.6	143.3	(13.7)
Хувь хүн орлогын албан татвар	28.5	42.0	(13.5)
Хөрөнгийн албан татвар	16.0	17.8	(1.8)
Шууд бус орлого	10.5	20.7	(10.2)
Үйл ажиллагааны орлого	2.0	3.5	(1.5)
Бууны албан татвар	1.0	1.5	(0.5)
Бууны албан татвар	1.0	1.5	(0.5)
Малын тоо толгойн албан татвар	76.4	49.9	26.5
Малын тоо толгойн албан татвар	76.4	49.9	26.5
Бусад Нийтлэг, төлбөр, хураамж	14.7	22.9	(8.2)
Улсын тэмдэгтийн хураамж	1.7	1.4	0.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	12.0	18.1	(6.1)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.0	3.4	(2.4)
Газрын төлбөр	0.8	4.2	(3.4)
Газрын төлбөр	0.8	4.2	(3.4)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2.9	6.7	(3.8)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.6	4.3	(2.7)
Ойн нөөц ашигласны төлбөр	-	0.7	(0.7)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.3	1.7	(0.4)
Татварын бус орлого	5.0	16.1	(11.1)
Нийтлэг татварын бус орлого	5.0	16.1	(11.1)
Торгуулийн орлого	4.0	15.1	(11.1)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.6	0.6	(0)
ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	0.4	0.4	(0)

Эх сурвалж: Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 143.3 сая төгрөг буюу 13.7 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 10.2, хөрөнгийн албан татварын орлого 1.8, үйл ажиллагааны орлого 1.5, Бууны албан татвар 0.5, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны 6.1, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.4, Газрын төлбөр 3.4, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 2.7, Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.4, Ойн нөөц ашигласны төлбөр 0.7, татварын бус орлого 11.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Улсын тэмдэгтийн хураамж 0.3, малын тоо толгойн орлого 26.5 сая төгрөгөөр тасалжээ.

Татварын бус орлого тасрах үндсэн шалтгаан нь СХС-гийн орлогыг 90.0 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс 41.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 48.6 сая төгрөгөөр тасалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 74.4 сая өмнөх оны авлага буюу татан төвлөрүүлэлтээс 1.6, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 54.1, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 38.4 сая төгрөг нийт 168.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 168.4 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 0,5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мянгад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2021 онуудад олгосон 83 зээлдэгчийн 366.3 сая төгрөгийн зээл олгогдсоноос 2 иргэн нас барсан, 41 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 15 иргэний 79.0 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 26 иргэний 127.0 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Тоосгон уул” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессын гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр төлбөр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Мянгад сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд сумын Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын үйлчилгээ үзүүлсний төлбөрт ЭМДС-аас авах 26.6 сая төгрөг, ОНХС-аас 35.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосонтой холбоотой авлага үүссэн асуудлууд нь нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Засаг даргын Тамгын газар нь шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй. Үүнд: ТГТ 1,5,8,11,12 дугаар сарууд хугацаа хоцорсон, бүх саруудын хэтрэлт, хэмнэлт тайлбаргүй, 2 дугаар улирал мэдээлээгүй, санхүүгийн тайлан (бүтэн,хагас жилээр) мэдээлээгүй, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт аудитын дүгнэлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг дутуу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг дутуу мэдээлснийг тайлангийн хугацаанд залруулсан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 67.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 50 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, олгосон санхүүжилтийн асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2 (сумын 12 жилийн сургууль, ЭМТөв,), “Хязгаарлалттай” -1 (Сумын хүүхдийн цэцэрлэг) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Мянгад сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 126.1 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрч, 96.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 29.3 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 0.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 29.3 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -5 /сая.төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мянгад сумын 12 жилийн сургууль	5	4.7	1	0.7					4	4.4
2	Мянгад сумын хүүхдийн цэцэрлэг	4	34.5	1	21.4	1	0.4			2	12.6
3	Мянгад сумын ЭМТ	4	86.9	2	74.6					2	12.3
	Дүн	13	126.1	6	96.7	1	0.4			6	29.3

Эх сурвалж: Мянгад сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 385.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7 алдаа зөрчлийн 118.0 сая төгрөгийн алдааг залруулж, 87.0 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 130.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 51.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд: ЗДТГ-ын

1. Хар үзүүрийн 2,4 сая төгрөгийн худгийн засварыг капиталжуулах,
2. И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг зарцуулахгүй байх, хувь хүний орлогын албан татварын 10 хувийн суутгал ногдуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 29.9 сая төгрөгийн,
3. авто машинд шатахуун олгосон нь явсан ажлын тайланг хавсаргаж оруулаагүй, жолооч нь замын хуудас өгдөггүй дутуу, шатахуун авч явсан албан тушаалтны

гарын үсэг байхгүй жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй 7.0 сая төгрөгийн,

4. Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй,
5. Тухайн байгууллагын өөрийн эзэмшилд байхгүй, хөрөнгийн шинж чанарыг агуулаагүй, хүүхдийн цэцэрлэгийн зургийн үнэ 10.0 сая төгрөгийг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн,
6. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 30.0 сая төгрөгөөр сумын айл өрхийн хашаа шинэчлэн сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэсэн байгаа нь УСНББОУС--17 -д нийцэхгүй,
7. ОНХС тайлант оны зардлыг 8.0 сая төгрөгөөр бууруулсан
8. Үр дүнгийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн 38.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулсан болно.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 115.4 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 04 дүгээр сарын 04-ны 28 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. *Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж 2021 оны 05 дугаар сарын 06- ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор СХС-аас төсөл сонгон шалгаруулах, зээл олгох үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөр тасалбар болгож зогсоох чиглэлийг ХХААХҮС-ын 2021.07.06-ны өдрийн 01/2191 албан тоот, Засаг даргын 1/1192 тоот албан тоотоор ирүүлсэн чиглэлийг зөрчиж 2021.07.29 - 2021.09.29 хүртэл хугацаанд 4 зээлдэгчид 28.0 сая төгрөгийн зээл олгосон, барьцаа хөрөнгийн эх хувиар нь баталгаажуулаагүй, тухайн суманд бүртгээгүй зээлдэгчид зээл олгосон зэрэг зөрчил дутагдал илэрлээ. Мөн тухайн зээлдэгч нарын зээл авсан мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулаагүй байна.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 4.2.1.-д “тухайн суманд бүртгэлтэй буюу байнга оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх”, 4.8.-д “Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална”, 5.2.-д “ Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана”, ХХААХҮС-ын 2021.07.06-ны өдрийн 01/2191 албан тоот, Засаг даргын 1/1192 албан тоот чиглэлийг заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 28.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

2. *Өмнөх оны Мянгад сумын ТТЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-аас 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан төлөөлөгч хөтөлбөрийн 8.0 сая төгрөгийн төсөл хөтөлбөр нь нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагааг төлөвлөж баталсан, хэрэгжүүлсэн зөрчил дутагдал илэрч дахин төлөвлөхгүй байх зөвлөмж өгөгдсөн байна.*

2022 оны ОНХС-ийн төлөвлөлтөд төлөөлөгчийн хөтөлбөрт 20.0 сая төгрөг, жишиг хашаа 30.0 сая төгрөг, Засаг даргын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр 8.0 сая төгрөг нийт 58.0 сая төгрөгийг баталсан нь өмнөх оны СТА өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хууль 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 60.3.4.-д “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа, 60.3.1.орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ, ОНХС -ийн үйл ажиллагааны журмын 4.3.2.-д “ОНХС-ийн

хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” 4.2.4.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны СТА өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт биелүүлээгүй тул 58.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

3. Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн цэвэр бохир усны хөнгөлөлтөд 3.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан цэвэр ус түгээдэг хүнтэй гэрээ байгуулан сар бүр 261 айл өрхөд ундны ус түгээж холбогдох зардалд 2.0 сая төгрөгийн олгож 1.0 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан зөрчил дутагдал илэрсэн нь Засгийн газрын тогтоолын хэрэгжилт хангаагдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Байгаль орчны барьцаа төлбөртэй холбоотой

1.Илрүүлэлт: Тайлант онд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 6 аж ахуйн нэгжээс байгаль орчны барьцаа төлбөр болох 2.5 сая төгрөгийг СХС дансанд төвлөрүүлж зориулалт бусаар зарцуулж байгаа нь хуулийн хэрэгжилт хангаагдаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө. 38.1.8-д “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, БОНХС-ын 2014 оны А/04 тушаал 2.3.2.ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг “Ашигт малтмалын тухай” хуулийн 38.1.8-д заасан хувь хэмжээгээр” төвлөрүүлэх гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах Комиссын дүгнэлт, байгаль орчны хуваарьт аудитын тайлан, төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын болон Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн баталгааны мөнгөн хөрөнгийн зохих хувийг төсөл хэрэгжүүлэгчид буцаан олгох эсэх асуудлыг төрийн захиргааны төв байгууллага эсвэл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шийдвэрлэнэ гэснийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах албан шаардлага өглөө

Зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал

2.Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн 145.2 сая төгрөгийн зээлээс 26 иргэний 127.6 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, зээлийн авлага төлөгдөөгүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.1.4-д "авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаанд төлөөгүй

тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар мөн зохих журмын дагуу зээлийг төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна", 3.4-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаан асуудлыг 2 тал хамтран оролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхгүй боломжгүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.1 Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаандаа төлөөгүй 26 зээлдэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн сангийн эргэцийг сайжруулан ажиллах албан шаардлага өглөө.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.ОНХС-ийн хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, хүлээж авах ажлын хэсгийн томилоогүй, хөтөлбөрийн хүрэх үр дүнг тооцдоггүй зөрчил дутагдал нийтлэг байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ гэсэн журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

2.ОНХС-ийн хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл 37, "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын "аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна. Сумын удирдлага ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулсан 5.3 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

3.Засгийн газрын тогтоолын хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй. Үүнд: шинэ жилийн арга хэмжээ, шагнал, бусад арга хэмжээ, ажиллагсдад үр дүнгийн урамшуулал хавтгайруулж олгосон зэрэг төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Бүх шатны төсөв захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1. "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

4.Он дамжсан насжилт өндөртэй, авлагыг тодорхойлж барагдуулаагүй

Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхой бус 7.6 сая төгрөгийн барагдаагүй авлага бүртгэлтэй байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй авлагыг барагдуулан, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мянгад ЗДТГ	6	83.0	4	39.5	-	-			2	43.5
2	Мянгад ИТХ	-	-								
3	Мянгад Соёлын төв	1	2.2							1	2.2
4	Мянгад ОНХС	5	141.3	3	78.0	1	58.00			1	5.3
5	Мянгад СХС	4	159.1			2	29.00	2	130.10		
6	Мянгад Шим ус	0	-					0			
Дүн		16	385.6	7	118	3	87	2	130	4	51

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ